

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## Агуулга

1. Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1. Ерөнхий зүйл .....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	11
3.4. Материаллаг байдал.....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл.....	12
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.9. Аудитын илрүүлэлт .....	13
Аудитын зөвлөмж .....	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	14
4. Менежментийн захидал.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	15



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЦАГААННУУР ЧӨЛӨӨТ БҮСИЙН  
ЗАХИРАГЧ А.АМАНКЕЛДИ  
ТАНАА

2021.02.25 № 07/567  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагааннуур чөлөөт бүсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагааннуур чөлөөт бүсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Цагааннуур чөлөөт бүс нь 3 зорилтын хүрээнд 12 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

**2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>7,004,940.62</u></b>	<b><u>4,398,740.35</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	4,940.00	4,940.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	4,940.00	4,940.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	4,940.00	4,940.00
31213	Арилжааны банк дахь харилцах	4,940.00	4,940.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	429,562.04	379,534.53
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	429,562.04	379,534.53
3351	Байгууллагаас авах авлага	50,029.75	2.24
3352	Хувь хүмүүсээс авах авлага	379,532.29	379,532.29
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	1,681,929.57	1,196,970.81
34600	Урьдчилж гарсан зардал	1,681,929.57	1,196,970.81
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	4,888,509.01	2,817,295.01
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	256,200.00	-
35110	Тусгай зориулалттай материал	256,200.00	-
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	4,632,309.01	2,817,295.01
35410	Бичиг хэргийн материал	1,969,061.01	1,469,369.01
35470	Бусад хангамжийн материал	2,663,248.00	1,347,926.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>815,786,331.22</u></b>	<b><u>766,801,674.68</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	815,786,331.22	766,801,674.68
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	810,319,681.17	761,716,424.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	834,893,774.80	834,893,774.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	(47,229,796.08)	(94,459,592.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	38,000,000.00	38,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(38,000,000.00)	(38,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	59,534,616.50	61,504,616.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,521,959.40)	(43,328,999.98)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,963,772.66	5,963,772.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,562,727.31)	(3,099,147.23)
39217	Ном	242,000.00	242,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	5,466,650.05	5,085,250.09
39301	Програм хангамж	4,804,000.00	5,398,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,103,549.95)	(2,078,949.91)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,766,200.00	1,766,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>822,791,271.84</u></b>	<b><u>771,200,415.03</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>822,791,271.84</u></b>	<b><u>771,200,415.03</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	822,791,271.84	771,200,415.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	72,629,683.00	72,629,683.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	72,629,683.00	72,629,683.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	648,108,554.32	596,517,697.51
51210	Өмнөх үеийн үр дүн	648,108,554.32	648,108,554.32
51220	Тайлант үеийн үр дүн	-	(51,590,856.81)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	102,053,034.52	102,053,034.52
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>822,791,271.84</u></b>	<b><u>771,200,415.03</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөгөөр/

<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>308,282,100.00</b>	<b>352,161,200.00</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	-	-
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,040,000.00</b>	<b>5,040,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>5,040,000.00</b>	<b>5,040,000.00</b>
120005	Түрээсийн орлого	5,040,000.00	5,040,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>303,242,100.00</b>	<b>347,121,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>303,242,100.00</b>	<b>347,121,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	303,242,100.00	347,121,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>365,735,514.10</b>	<b>403,752,056.81</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>365,735,514.10</b>	<b>403,752,056.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>353,050,265.52</b>	<b>346,442,547.93</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>195,882,591.11</b>	<b>213,815,257.42</b>
210101	Үндсэн цалин	141,249,558.31	151,305,863.06
210102	Нэмэгдэл	37,107,932.80	45,155,894.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,525,100.00	17,353,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>24,984,417.59</b>	<b>26,884,407.39</b>
210201	Тэтгэврийн даатгал	17,074,268.00	18,281,396.78
210202	Тэтгэмжийн даатгал	1,825,598.47	2,150,752.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,756,848.95	1,720,601.98
210204	Ажилгүйдлийн даатгал	393,427.42	430,150.72
210205	Эрүүл мэндийн даатгал	3,934,274.75	4,301,505.21
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>34,952,800.00</b>	<b>30,709,535.44</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,298,000.00	913,125.44
210302	Түлш, халаалт	3,500,000.00	198,000.00
210303	Цэвэр, бохир ус	450,000.00	
210304	Байрны түрээс	29,704,800.00	29,598,410.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,495,542.58</b>	<b>13,215,436.14</b>
210401	Бичиг хэрэг	2,980,302.16	2,782,442.00
210402	Тээвэр, шатахуун	5,215,903.00	3,667,660.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,299,337.42	3,740,036.14
210408	Бараа материал акталсны зардал	-	3,025,298.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,622,444.00</b>	-
210604	Урсгал засвар	14,622,444.00	
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,733,100.00</b>	-
210702	Дотоод албан томилолт	5,733,100.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,145,950.00</b>	<b>8,641,255.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,196,000.00	5,717,755.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,999,950.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	348,600.00	348,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	199,900.00	202,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,336,500.00	312,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,000.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>58,233,420.24</b>	<b>53,176,656.54</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	58,233,420.24	53,176,656.54
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12,685,248.58</b>	<b>57,309,508.88</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>900,000.00</b>	<b>25,482,579.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	25,113,579.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	369,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>11,785,248.58</b>	<b>31,826,929.88</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,785,248.58	31,826,929.88

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(57,453,414.10)	(51,590,856.81)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(57,453,414.10)	(51,590,856.81)

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>309,332,100.00</b>	<b>352,161,200.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,090,000.00</b>	<b>5,040,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>6,090,000.00</b>	<b>5,040,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,040,000.00	5,040,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,040,000.00	5,040,000.00
120009	Бусад орлого	1,050,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>303,242,100.00</b>	<b>347,121,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>303,242,100.00</b>	<b>347,121,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	303,242,100.00	347,121,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>309,342,100.00</b>	<b>352,161,200.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>309,342,100.00</b>	<b>352,161,200.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>296,656,851.42</b>	<b>294,851,691.12</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>195,612,594.00</b>	<b>213,765,230.81</b>
210101	Үндсэн цалин	154,746,794.00	162,201,045.80
210102	Нэмэгдэл	28,058,000.00	38,242,085.01
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,807,800.00	13,322,100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>24,984,328.00</b>	<b>26,884,406.49</b>
210201	Тэтгэврийн даатгал	17,063,045.23	18,287,949.53
210202	Тэтгэмжийн даатгал	2,009,254.01	2,149,063.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,576,540.61	1,719,409.78
210204	Ажилгүйдлийн даатгал	394,135.65	429,653.44
210205	Эрүүл мэндийн даатгал	3,941,352.50	4,298,330.49
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>34,952,800.00</b>	<b>31,501,535.44</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,298,000.00	913,125.44
210302	Түлш, халаалт	3,500,000.00	990,000.00
210303	Цэвэр, бохир ус	450,000.00	-
210304	Байрны түрээс	29,704,800.00	29,598,410.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,011,635.42</b>	<b>9,867,263.38</b>
210401	Бичиг хэрэг	3,431,698.00	2,542,600.00
210402	Тээвэр, шатахуун	4,960,600.00	4,029,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,619,337.42	3,295,063.38
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,622,444.00</b>	<b>3,598,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,598,000.00
210604	Урсгал засвар	14,622,444.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,733,100.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	5,733,100.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,739,950.00</b>	<b>9,235,255.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,790,000.00	5,717,755.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,999,950.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	348,600.00	348,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	199,900.00	202,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,336,500.00	906,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,000.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12,685,248.58</b>	<b>57,309,508.88</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>900,000.00</b>	<b>25,482,579.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	25,113,579.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	369,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>11,785,248.58</b>	<b>31,826,929.88</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,785,248.58	31,826,929.88
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(10,000.00)</b>	<b>≡</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(10,000.00)</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>14,940.00</b>	<b>4,940.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>4,940.00</b>	<b>4,940.00</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	72,629,683.00	102,053,034.52	704,405,966.89	879,088,684.41
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,156,001.53	1,156,001.53
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>72,629,683.00</b>	<b>102,053,034.52</b>	<b>705,561,968.42</b>	<b>880,244,685.94</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-57,453,414.10	-57,453,414.10
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>72,629,683.00</b>	<b>102,053,034.52</b>	<b>648,108,554.32</b>	<b>822,791,271.84</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>72,629,683.00</b>	<b>102,053,034.52</b>	<b>648,108,554.32</b>	<b>822,791,271.84</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	-51,590,856.81	-51,590,856.81
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>72,629,683.00</b>	<b>102,053,034.52</b>	<b>596,517,697.51</b>	<b>771,200,415.03</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>347,621,200.00</b>	<b>320,334,270.12</b>	<b>27,286,929.88</b>	<b>92.2</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>347,621,200.00</b>	<b>320,334,270.12</b>	<b>27,286,929.88</b>	<b>92.2</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>321,295,000.00</b>	<b>294,851,691.12</b>	<b>26,443,308.88</b>	<b>91.8</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>229,772,500.00</b>	<b>213,765,230.81</b>	<b>16,007,269.19</b>	<b>93.0</b>
210101	Үндсэн цалин	180,099,300.00	162,201,045.80	17,898,254.20	90.1
210102	Нэмэгдэл	36,865,400.00	38,242,085.01	(1,376,685.01)	103.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,807,800.00	13,322,100.00	(514,300.00)	104.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>31,019,200.00</b>	<b>26,884,406.49</b>	<b>4,134,793.51</b>	<b>86.7</b>
210201	Тэтгэврийн даатгал	21,828,400.00	18,287,949.53	3,540,450.47	83.8
210202	Тэтгэмжийн даатгал	2,297,700.00	2,149,063.25	148,636.75	93.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,838,200.00	1,719,409.78	118,790.22	93.5
210204	Ажилгүйдлийн даатгал	459,500.00	429,653.44	29,846.56	93.5
210205	Эрүүл мэндийн даатгал	4,595,400.00	4,298,330.49	297,069.51	93.5
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>32,666,100.00</b>	<b>31,501,535.44</b>	<b>1,164,564.56</b>	<b>96.4</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,298,000.00	913,125.44	384,874.56	70.3
210302	Түлш, халаалт	1,000,000.00	990,000.00	10,000.00	99.0
210303	Цэвэр, бохир ус	495,000.00	-	495,000.00	-
210304	Байрны түрээс	29,873,100.00	29,598,410.00	274,690.00	99.1
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,342,500.00</b>	<b>9,867,263.38</b>	<b>475,236.62</b>	<b>95.4</b>
210401	Бичиг хэрэг	2,543,300.00	2,542,600.00	700.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	4,029,600.00	4,029,600.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,769,600.00	3,295,063.38	474,536.62	87.4
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,600,000.00</b>	<b>3,598,000.00</b>	<b>2,000.00</b>	<b>99.9</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,600,000.00	3,598,000.00	2,000.00	99.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,894,700.00</b>	<b>9,235,255.00</b>	<b>4,659,445.00</b>	<b>66.5</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,290,300.00	5,717,755.00	4,572,545.00	55.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	348,600.00	348,600.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	288,000.00	202,500.00	85,500.00	70.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	60,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	907,800.00	906,400.00	1,400.00	99.8
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>26,326,200.00</b>	<b>25,482,579.00</b>	<b>843,621.00</b>	<b>96.8</b>

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>26,326,200.00</b>	<b>25,482,579.00</b>	<b>843,621.00</b>	<b>96.8</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,957,200.00	25,113,579.00	843,621.00	96.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	369,000.00	369,000.00	-	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>347,621,200.00</b>	<b>352,161,200.00</b>	<b>(4,540,000.00)</b>	<b>101.3</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	347,121,200.00	347,121,200.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	347,121,200.00	347,121,200.00	-	100.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>500,000.00</b>	<b>5,040,000.00</b>	<b>(4,540,000.00)</b>	<b>1,008.0</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	5,040,000.00	(4,540,000.00)	1,008.0
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		4,940.00	(4,940.00)	-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		4,940.00	(4,940.00)	-
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>18</b>	<b>18</b>	-	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	13	13	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	-	100.0

### 3. АУДИТЫН ТАЙЛАН

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Цагааннуур чөлөөт бүсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирагч А.Аманкелди танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын гэрээгээр Хаан консалтинг Аудит ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Ганцэцэг, гүйцэтгэх захирал Э.Нандинчимэг, аудитор Б.Үжин хариуцаж гүйцэтгэв.

Цагааннуур чөлөөт бүсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний Аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Цагааннуур чөлөөт бүсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Чөлөөт бүсийн орон тооны бус зөвлөл нь Засгийн газраас чөлөөт бүсийн талаар баримтлах бодлого чиглэлийг боловсруулах, чөлөөт бүсүүдийг хөгжүүлэхэд гарч байгаа хүндрэл бэрхшээлийг судлан нэгтгэж дүгнэлт гаргах, чөлөөт бүсүүдийн

хөгжлийн талаар олон улсын туршлага судалсны үндсэн дээр Монголын чөлөөт бүсүүдийн худалдаа, эдийн засгийн ерөнхий төсөөллийг тооцоолон гаргах, чөлөөт бүсүүдийн захирагчийн албаны үйл ажиллагааны талаар санал зөвлөмж боловсруулах, Улсын Их хурал, Засгийн газраас чөлөөт бүсүүдийн талаар гаргасан шийдвэрийн хэрэгжүүлэлтэнд хяналт тавих;

- Цагааннуур чөлөөт худалдааны бүс байгуулах зорилго нь бүсэд үзүүлэх хөнгөлөлтүүдэд тулгуурлан гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оруулж олон улсын худалдаа, жижиг дунд үйлдвэр, аялал жуулчлалын үйл ажиллагааг хөгжүүлэн ажилгүйдэл, ядуурлыг багасгаж улс орны хөгжилд тодорхой түлхэц үзүүлэх.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Цагааннуур чөлөөт бүсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сангийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хяналт шалгалт хийгдээгүй байна.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 403,752.0 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 8,075.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Цагааннуур чөлөөт бүсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 51,590.9 мянган төгрөгөөр буюу 6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үзүүлэлт байхгүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4.9	4.9	-
Авлага	429.6	379.5	50.1
Урьдчилгаа	1,681.9	1,197.0	484.9
Бараа материал	4,888.5	2,817.3	2,071.2
Үндсэн хөрөнгө	945,204.4	947,768.4	2,564.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>822,791.3</b>	<b>771,200.4</b>	<b>-51,590.9</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	72,629.7	72,629.7	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>822,791.3</b>	<b>771,200.4</b>	<b>-51,590.9</b>

Авлага дансны үлдэгдэл 379.5 мянган төгрөг болж 50.1 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны байгууллагаас авах авлага төлөгдсөнөөс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,817.3 мянган төгрөг болж 2,071.2 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материал болон хангамжийн материалыг акталснаас шалтгаалсан байна. Бараа материалын дансанд 1,469.4 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 1,347.9 мянган төгрөгийн хангамжийн материал байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 947,768.4 мянган төгрөг болж 2,564.0 мянган төгрөгөөр өссөн нь 3,598.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, 594.0 мянган төгрөгийн программ хангамж худалдан авсанаас шалтгаалсан байна.

ТӨБЗГ-ын 2020 оны А-1/1882 дугаар тогтоолыг үндэслэн 1,628.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

Цагааннуур чөлөөт бүсийн тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 43,879.1 мянган төгрөгөөр буюу 12.0 хувиар өссөн байна.

Улсын төсвөөс санхүүжих орлого 43,879.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өмнөх оноос илүү төсөв батлагдсантай холбоотой.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 6,607.7 мянган төгрөгөөр буюу 2 хувиар буурсан байна. Энэ нь тайлант онд урсгал засвар, томилолт зочны зардал гараагүй, цар тахлын үед хэмнэлтийн горимд шилжиж хөл хорио тогтоосонтой холбоотой байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг 370,628.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн бөгөөд төсөв 347,621.2 мянган төгрөгөөр батлагдсан.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 347,621.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 347,121.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 347,121.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 5,040.0 мянган төгрөг, нийт 352,161.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 320,334.3 мянган төгрөгийг зарцуулж 31,826.93 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 320,334.3 мянган төгрөг буюу 92.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 16,007.3 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 4,134.8 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,164.6 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 475.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэлттэй зарцуулсантай холбоотой.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **Улсын төсөвт төвлөрүүлэх орлого**

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар 2020 онд 500.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 5,040.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 1008.0 хувиар биелүүлсэн байна.

**Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого**

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
			Зөрүү	Хувь
Туслах үйл ажиллагааны орлого	500.0	5,040.0	4,540.0	1008.0
<b>Нийт дүн</b>	<b>500.0</b>	<b>5,040.0</b>	<b>4,540.0</b>	<b>1008.0</b>

Баян-Өлгий аймаг дахь оффисын байрыг үүрэн телефоны компаниудтай ТӨБЗГ-тай гурвалсан түрээсийн гэрээ байгуулж нийт 7,200.0 мянган төгрөгийн орлого 30 хувь болох 2,160.0 мянган төгрөгийг ТӨБЗГ-т шилжүүлж үлдэгдэл 5,040.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

**3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 141 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 26,160.3 мянган төгрөгийн 8 мэдээлэл байна.

**3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5,892.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 зөвлөмжийг биелүүлсэн байна.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	5,892.9	4	5,892.9	-	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>5,892.9</b>	<b>4</b>	<b>5,892.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>100.0</b>

**3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 2,074.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 2,074.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Харилцагч байгууллагуудтай хийсэн гэрээний хэрэгжилтийг шалгах, мөн худалдан авалт хийхдээ татвар төлөгч байгууллагуудаас худалдан авалт хийж нэмэгдсэн өртгийн албан татварын зөрүү үүсгэхгүй байхад анхаарах нь зүйтэй байна.

Дэлхийг хамарсан Ковид-19 цар тахал тархаж, хатуу хөл хорио тогтоосноос шалтгаалан цахимаар аудитыг гүйцэтгэсэн нь үндсэн хөрөнгө, бараа материалын дансны үлдэгдэлд биет тест хэрэгжүүлэн тооллогын үлдэгдэлтэй тулган баталгаажуулах боломжгүй байсныг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй.

#### **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **1. Түрээсийн гэрээтэй холбоотой асуудал**

- 1.1. Илрүүлэлт: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт төвлөрүүлэх орлогыг 720.0 мянган төгрөгөөр дутуу шилжүүлсэн.
- 1.2. Эрсдэл: Төрийн өмчийн өөрийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний хэрэгжилт хангагдахгүй, төлөвлөгөөт орлого хэрэгжихгүй байх.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журмын 17 дугаар зүйл “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар төвлөрүүлж улсын төвлөрсөн төсөвт оруулна. Улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хувь, хэмжээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тогтооно” заалтыг мөрдөх.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

##### **2. Худалдан авалттай холбоотой асуудал**

- 2.1. Илрүүлэлт: Харилцах дансны хуулгыг төлбөрийн цахим системд бүртгэгдсэн худалдан авалтын баримттай тулгахад 1,354.4 мянган төгрөгийн баримт илгээгдээгүй, баталгаажуагүй байна.
- 2.2. Эрсдэл: Худалдан авалтыг цахим татварын системд тайлагнаагүй байгаа нь худалдан авалт бодитоор хийгдээгүй байх.
- 2.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-т заасан “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг дагаж мөрдөх.
- 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ**

Огноо: <b>2021.02.25</b>	Аудитын нэр: <b>Цагааннуур чөлөөт бүсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>САГ-2021/13/СТА-ТШЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр: <b>Цагааннуур чөлөөт бүс</b>	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаа с гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Түрээсийн гэрээнд 720.0 мянган төгрөгийг ТӨБЗГ-т дутуу шилжүүлсэн.	720.0	Зөвлөмж өгөх	Захирагч Нягтлан бодогч	А.Аманкелди М.Аманкелди
2	Харилцах дансны хуулгыг төлбөрийн цахим системд Бүртгэгдсэн баримттай тулгахад 1,354.4 мянган төгрөгийн баримт баталгаажаагүй байна.	1,354.4	Зөвлөмж өгөх	Захирагч Нягтлан бодогч	А.Аманкелди М.Аманкелди
<b>ДҮН</b>		<b>2,074.4</b>			